



НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ

НЭГ.ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү журмаар Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) -ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх)-ны үйл ажиллагаа явуулах журам, бүрэлдэхүүн, гишүүдийг томилох, чөлөөлөх болон Компанийн засаглалын кодекст заасан холбогдох бусад харилцааг зохицуулна.
- 1.2 Хороо нь ТУЗ-ийн гишүүн болон компанийн эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүн, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид нь тавигдах шаардлагыг хангасан эсхийг үнэлэн шалгаж, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах болон томилогдон ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд нь шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахад анхаарах асуудлыг хариуцна.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Хороо нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, зохицуулагч байгууллагын тогтоол, эрх зүйн актууд, компанийн засаглалын кодекс болон энэхүү журмыг баримтална.
- 2.2 Энэхүү журмыг хорооны дарга, гишүүд, нарийн бичиг болон асуудал танилцуулж байгаа аливаа албан тушаалтан бүгд мөрдөнө.

ГУРАВ.НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- 3.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 3.1.1. “ТУЗ” гэж Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийг удирдах, олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтцийг;
 - 3.1.2. “ТУЗ-ийн гишүүн” гэж төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүнийг;
 - 3.1.3. “ТУЗ-ийн хараат бус гишүүн” гэж компанийн тухай хуулийн 79.1-т заасан шалгуурыг хангасан этгээдийг;
 - 3.1.4. “Эрх бүхий албан тушаалтан” гэж компанийн дүрэмд заасны дагуу гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогчийг;

ДӨРӨВ.ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

- 4.1 Хороо нь дараах чиг үүрэгтэй байна:
 - 4.1.1. ТУЗ-ийн гишүүн болон эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
 - 4.1.2. ТУЗ-ийн болон компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд хууль, дүрмэнд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;
 - 4.1.3. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх
 - 4.1.4. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорих ба хүйсийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;
 - 4.1.5. ТУЗ-ийн залгамж халааг төлөвлөж, хэрэгжүүлэх бодлого боловсруулах;



ГЭРЭЛ ФИНАНС
БАНС БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛАГА

- 4.1.6. Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тодорхойлох, түүний дотор цалин, шагнал урамшууллыг олгох шалгуурыг тогтоох;
- 4.1.7. ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах хэрэгтэй чиглэлээр ТУЗ-ийн гишүүдэд тогтмол мэргэжлийн сургалт зохион байгуулах;
- 4.1.8. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүнд гишүүний үүрэг хариуцлагыг тодорхой заасан удирдамж, зааварчилгаа, шаардлагатай чиглүүлэх сургалтаар хангах;
- 4.1.9. ТУЗ-аас үүрэг болгосон бусад асуудал.

ТАВ.ХОРОО БОЛОН ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Хороо нь дараах үүрэг хүлээж, эрх эдэлнэ:
 - 5.1.1. Компанийн гүйцэтгэх удирдлагаас бичиг баримт, тайлан, тайлбар болон бусад төрлийн мэдээллийг шаардах эрхтэй;
 - 5.1.2. Компанийн удирдах албан тушаалтан, менежер, мэргэлжилтнүүдийг өөрийн хуралд ажиглагчаар оролцуулах мөн асуулт, тайлбар болон тодруулга авах эрхтэй;
 - 5.1.3. Хороо нь энэхүү журмыг жил бүр хянаж, ТУЗ-д зохистой өөрчлөлт хийх талаар дүгнэлт гаргах эрхтэй;
 - 5.1.4. Хороо нь жилдээ хамгийн багадаа нэг удаа үйл ажиллагааны тайлангаа ТУЗ-д тайлагнах үүрэгтэй;
 - 5.1.5. Журамд заасан чиг үүргийн хүрээнд ТУЗ-аас шаардсан бусад үүрэг гүйцэтгэх.
- 5.2 Хорооны гишүүд дараах үүрэг хүлээж, эрх эдэлнэ:
 - 5.2.1 Хорооны бүх хуралд оролцох үүрэгтэй байна;
 - 5.2.2 Албан ажил гүйцэтгэх явцад олж авсан компанийн болон хувийн мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй;
 - 5.2.3 Хорооны шийдвэртэй холбоотой ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдалд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй;
 - 5.2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 8.15-д заасны дагуу хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөө, үйлчилгээг авах эрхтэй;

ЗУРГАА.ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН БА ГИШҮҮНИЙГ СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ

- 6.1 Хороо нь 3 ба түүнээс дээш сондгой тооны гишүүнтэй байх ба гишүүнийг ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 6.2 Хорооны гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшүүлэх хорооны даргыг сонгоно.
- 6.3 ТУЗ нь аль болох хараат бус гишүүдийг Хорооны гишүүнээр сонгох зарчмыг баримтлах бөгөөд Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь заавал хараат бус гишүүнээс бүрдсэн байна.
- 6.4 Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.
- 6.5 Зөвхөн ТУЗ-ийн гишүүн Хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй.
- 6.6 Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.
- 6.7 Хорооны гишүүд компанийн үндсэн удирдлага болон бусад холбогдох ажилтнуудтай харилцан ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар туршлагатай байна. Гишүүдэд тавигдах шаардлага нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын Дөрөв-р бүлэгт заасны дагуу байна.
- 6.8 ТУЗ нь Хорооны гишүүнийг хэзээ ч ажлаас чөлөөлөх эсвэл хорооны бүрэлдэхүүнийг бүхэлд нь шинэчлэх эрхтэй байна.
- 6.9 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана.



ГЭРЭЛ ФИНАНС
БАНК БҮС САНХҮҮГИЙН БАЙГУУЛАГА

- 6.10 ТУЗ-ийн гишүүнийг улируулан томилох асуудлыг хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцүүлэхдээ гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, ТУЗ-ийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээллийг танилцуулна.

ДОЛОО.ХОРООНЫ ХУРЛЫН ДЭГ, ЖУРАМ

- 7.1 Хороог гишүүдийн олонхын саналаар томилсон дарга удирдана.
- 7.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хорооны нарийн бичгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэнэ.
- 7.3 Хорооны ажил, үйл ажиллагааны явуулах үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд хорооны хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 7.4 Ээлжит хурлыг 6 сард нэг удаа хуралдуулна. Ээлжит бус хурлын компанийн үйл ажиллагаа шийдвэрлэх асуудлаас хамааран хэдийд ч Хорооны дарга, гишүүний санал, ТУЗ-ийн шийдвэр болон компанийн гүйцэтгэх удирдлагын санаачлагаар зарлан хуралдуулж болно.
- 7.5 Хэрэв ТУЗ-ийн хурлаар Хорооны чиг үүрэгтэй холбоотой асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн бол хороо нь ТУЗ-ийн хурал болох өдрөөс 2-оос дошгүй хоногийн өмнө хуралдана.
- 7.6 Хурлыг биеэр, саналын хуудсаар, утсаар, цахим хэлбэрээр явуулж болох ба Хорооны гишүүдийн дийлэнх олонх (2/3) бүрдсэн тохиолдолд хурлын ирц бүрдсэнд тооцно.
- 7.7 Хорооны нарийн бичгийн дарга хурал болохоос 3-оос доошгүй хоногийн өмнө хорооны гишүүн бүрт хурал болох огноо, газар, эхлэх цаг, хэлэлцэх асуудлын талаарх мэдэгдэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой болон хуралд бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг Нарийн бичгийн даргад бүртгэлтэй байгаа цахим хаягаар нь хүргүүлнэ.
- 7.8 Хурлын явцад тэмдэглэл хөтлөх ба Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна.
- 7.9 Хороо тодорхой асуудал хэлэлцэж дуусмагц дүгнэлт бичгээр үйлдэж, хуралд оролцсон бүх гишүүдийн гарын үсгийг авах ба уг дүгнэлтээ ТУЗ-ийн дарга эсвэл ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.
- 7.10 Хуралд оролцсон гишүүдийн дийлэнхийн саналаар дүгнэлтийг гаргана.
- 7.11 Хорооны дийлэнх гишүүдийн дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа гишүүн дийлэнхийн дүгнэлттэй хамт өөрийн дүгнэлтийг мэдүүлнэ.

НАЙМ.ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

- 8.1 Цалин хөлсний хэмжээ, олгох журмыг ТУЗ-ын цалин урамшуулын үйл ажиллагааны журмын дагуу тодорхойлно.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1. ТУЗ-ийн гишүүнд дараах хариуцлага хүлээлгэнэ.
- 9.1.1. Энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй, дотоод мэдээллийг задруулсан, буруу шийдвэр гаргаснаас компанид ноцтой хохирол учруулаагүй гэж үзвэл анхааруулна.
- 9.1.2. Дээрх зөрчлийн улмаас компанид ноцтой хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлүүлэх тухай асуудлыг тухайн гишүүнд хугацаатай үүрэг өгөх замаар шийдвэрлэх бөгөөд ингэж шийдвэрлэж чадаагүй бол хуулийн байгууллагад хандаж, тухайн этгээдийг ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлнө.